



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/60

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Наурыз”-ын баярыг тохиолдуулан аймагт зохион байгуулах харилцаа дууны “Айтыс-2019” олон улсын наадмыг зохион байгуулах арга хэмжээнд зарцуулах төсвийг 10,0 сая төгрөг /Арван сая/-өөр хавсралтаар баталсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 10,0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.32 дахь заалтын “Олон улсын “Айтыс-2019” дууны наадам арга хэмжээ”-ээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Казах үндэсний соёлын үнэт өв болсон Харилцаа дууны “Айтыс” наадмыг өндөр түвшинд зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ажлын хэсгийн ахлагч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 14-ний өдрийн
А/160 дугаар захирамжийн хавсралт



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА ДУУНЫ "ХОВД АЙТЫС-2019" НААДМЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Эзлэх байр	Хүний тоо	Мөнгөн шагнал	Медаль	Өргөмжлөл	Цом	Дүн
1	Тэргүүн байр /Гранпри/	1	1,000,000	15,000	40,000	250,000	1,305,000
2	1 дүгээр байр	1	800,000	15,000	40,000		855,000
3	2 дугаар байр	1	500,000	15,000	40,000		555,000
4	3 дугаар байр	1	350,000	15,000	40,000		405,000
5	Тусгай байрын шагнал	2	150,000		40,000		340,000
6	Оролцогчдын гарын бэлэг	35	50,000		5,000		1,755,000
7	Шүүгч нарын хөлс	7	50,000				350,000
8	Хөтлөгчийн хөлс	2	200,000				400,000
9	Тайз чимэглэлийн зардал	1	385,000				385,000
10	Тайз чимэглэлийн материалын зардал	1	300,000				300,000
11	Зочид буудал, хоолны зардал /2 өдөр*30 хүн/	30	80,000				2,400,000
12	Урлагийн номер, тоглолт /5 уран сайханч /	5	50,000				250,000
12	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1	500,000				500,000
13	Нэвтэрүүлэгийн зардал	1	200,000				200,000
Дүн			6,715,000	60,000	205,000	250,000	10,000,000

-oOo-